


**Иргэн, захиргааны хэргийн талаархи шийдвэр гүйцэтгэх ажиллагаа**

**ИРГЭНИЙ ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГААНЫ ТАЛУУДААС  
ГАРГАСАН ГОМДЛЫГ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХЭД АНХААРАХ  
АСУУДАЛ**

**THE CONCERNING PROBLEM OF REVIEW AND RESOLVE  
COMPLAINTS LODGED BY PARTIES TO CIVIL DECISION  
ENFORCEMENT PROCESS**



**Я.Батгэрэл**

*Дотоод хэргийн их сургуулийн  
Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн  
Иргэний шийдвэр гүйцэтгэлийн тэнхимийн эрхлэгч,  
хууль зүйн магистр, дэд хурандаа*

**Товч утга:** Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд шийдвэр гүйцэтгэгчийн явуулсан үйл ажиллагаа, гаргасан шийдвэрийг эс зөвшөөрч төлбөр төлөгч, төлбөр авагч, эрх ашиг сонирхол нь хөндөгдсөн гуравдагч этгээд тэдгээрийн төлөөлөгчдийн зүгээс гаргасан гомдлыг хянан шийдвэрлэхэд ахлах шийдвэр гүйцэтгэгчийн баримтлах зарчим, анхаарах асуудлыг тодорхойлохыг зорилоо.

**Түлхүүр үгс:** Гомдол, хянан шийдвэрлэх, үндэслэл

**Abstract:** It is intended to determine the principles and issues to be considered by the senior decision enforcer in handling complaints filed by payers, payees, and third parties whose interests are affected by their representatives, who disapprove of the actions and decisions made by the decision enforcer in.

**Keywords:** Complaints, reviews and grounds.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хууль дээдлэх, хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх, хүний эрх, эрх чөлөөг зөвхөн хуульд зааснаар хязгаарлах, энэрэнгүй, шуурхай байх зарчмыг баримтална.<sup>26</sup>

Дээрх зарчмын хүрээнд шийдвэр гүйцэтгэгч нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэж, үндэс, угсаа, хэл, арьсны

<sup>26</sup> Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. Уб., 2017. Төрийн мэдээлэл эмхэтгэл №24.

өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлахгүйгээр хүний эрхийг ханган ажиллах шаардлагатай. Гэхдээ зөвхөн хуульд заасан үндэслэл, журмын дагуу хүний эрх, эрх чөлөөнд хязгаарлалт тогтоодог эрх бүхий субъект юм.

Тухайлбал иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр, хуульд заасан тохиолдолд бусад байгууллага, албан тушаалтны шүүхээр баталгаажуулсан шийдвэрийг үндэслэн явуулах бөгөөд шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад иргэний шийдвэр гүйцэтгэлийг баталгаажуулах арга хэмжээг авна.

Иргэний шийдвэр гүйцэтгэлийг баталгаажуулах арга хэмжээ гэж “Гүйцэтгэх баримт бичгийн шаардлагыг албадан гүйцэтгэх, эсхүл төлбөр төлөгчийг гүйцэтгэх баримт бичигт заасан шаардлагыг тогтоосон хугацаанд бүрэн гүйцэтгэх нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн шийдвэр гүйцэтгэгчийн хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу хэрэгжүүлэх арга хэмжээг ойлгоно”<sup>27</sup>. Үүнд:

- иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талууд /төлөөлөгчид/, бусад хүн, хуулийн этгээдийн төлөөллийг дуудан ирүүлэх;
- иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талууд /төлөөлөгчид/, бусад хүн, хуулийн этгээдээс гүйцэтгэх баримт бичгийн шаардлагыг биелүүлэхэд шаардлагатай баримт бичиг, лавлагаа, тодорхойлолт гаргуулан авах;
- төлбөр төлөгч болон бусад этгээдээс төлбөр төлөгчийн хөрөнгийн тухай мэдүүлэг гаргуулан авах, түүнийг төлбөртэй этгээдийн бүртгэлд бүртгэх;
- төлбөр төлөгчийн үйл ажиллагаанд холбогдох санхүүгийн болон бусад баримт бичигт үзлэг хийх;
- иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талууд /төлөөлөгчид/, бусад хүн, хуулийн этгээдэд гүйцэтгэх баримт бичгийн шаардлагыг хангах зорилгоор тодорхой үүрэг хүлээлгэх, энэ тухай мэдэгдэл хүргүүлэх;
- төлбөр төлөгч, түүний эд хөрөнгийг эзэмшиж, ашиглаж байгаа этгээдийн орон байрнаас бусад газар, барилга байгууламж, агуулах сав, эзэмшил газарт нэвтрэн орох, үзлэг хийх;
- төлбөр төлөгчийг албадан нүүлгэхээс бусад тохиолдолд ахлах шийдвэр гүйцэтгэгчийн зөвшөөрснөөр төлбөр төлөгч, түүний эд хөрөнгийг эзэмшиж, ашиглаж байгаа этгээдийн орон байранд нэвтрэн орох, үзлэг хийх;
- гүйцэтгэх баримт бичгийн шаардлагыг биелүүлэх зорилгоор төлбөр төлөгчийн бие, бэлэн мөнгө, бусад хөрөнгөд үзлэг хийх, тэдгээрийг

---

<sup>27</sup> Мөн тэнд.

- битүүмжлэх, барьцаалах, хураан авах, худалдан борлуулах, хураан авсан эд зүйл, хөрөнгийг хадгалуулах, хамгаалуулахаар хүлээлгэн өгөх;
- хуульд заасан үндэслэл, журмын дагуу битүүмжилсэн, барьцаалсан, хураан авсан эд зүйл, хөрөнгийг үнэлэх, уг ажиллагаанд үнэлгээчнийг оролцуулах;
  - төлбөр төлөгч, түүний эд хөрөнгийг эрэн сурвалжлах;
  - төлбөр төлөгчийн эд хөрөнгө, түүний эрхийн бүртгэлийн талаар улсын бүртгэлийн байгууллагад хандах, лавлагаа, тодорхойлолт гаргуулах;
  - иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны оролцогчоос гаргасан гомдлыг хянан шийдвэрлэх;
  - төлбөр төлөгчийн банк, эрх бүхий хуулийн этгээд дэх мөнгөн хадгаламж, харилцах дансан дахь хөрөнгөөс суутгал хийх, дансны зарлагын гүйлгээг хаах, банк, эрх бүхий хуулийн этгээдэд данс нээх, эзэмших эрхэд хязгаарлалт тогтоох, эсхүл эзэмшиж байгаа дансны орлого, зарлагын гүйлгээнд хяналт тавих;
  - төлбөр төлөгчийн улсын бүртгэлд бүртгэгдсэн эрхийг түдгэлзүүлэх;
  - төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх;
  - үл хөдлөх эд хөрөнгийг төлбөр авагчийн удирдлагад шилжүүлэх;
  - худалдан борлогдоогүй хөрөнгийг төлбөрт тооцон суутгаж төлбөр авагчид шилжүүлэх, уг зорилгоор албадан чөлөөлөх;

Шийдвэр гүйцэтгэгч баталгаажуулах арга хэмжээг явуулахдаа шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан арга журмын дагуу тогтоосон хугацаанд гүйцэтгэх бөгөөд зөрчсөн тохиолдолд шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талууд зөрчигдсөн эрхээ сэргээлгэхээр холбогдох эрх бүхий тушаалтанд гомдол гаргах үндэслэл үүснэ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд “Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талууд шийдвэр гүйцэтгэгчийн явуулсан арга хэмжээ, түүний гаргасан шийдвэрийг зөвшөөрөөгүй тохиолдолд тухайн арга хэмжээг гүйцэтгэсэн өдрөөс хойш, энэ тухай мэдээгүй бол олж мэдсэн өдрөөс хойш 7 хоногийн дотор ахлах шийдвэр гүйцэтгэгчид гомдол гаргаж болно. Ахлах шийдвэр гүйцэтгэгч гомдлыг 14 хоногийн дотор шийдвэрлэж, тогтоол гаргана. Тогтоолыг зөвшөөрөөгүй тохиолдолд хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор ерөнхий шийдвэр гүйцэтгэгчид, ерөнхий шийдвэр гүйцэтгэгчийн шийдвэрийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор шүүхэд гомдол гаргаж болно.”<sup>28</sup> гэж заасан.

Юуны өмнө гомдол гэж юуг ойлгох талаар авч үзье.

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд "гомдол гэж төрийн байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаагаар иргэдийн хуулиар хамгаалагдсан эрх, эрх

<sup>28</sup> Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. Уб., 2017. Төрийн мэдээлэл эмхэтгэл №24.

чөлөө, ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзэж сэргээлгэхээр гаргасан хүсэлтийг”<sup>29</sup>, “өргөдөл, гомдлыг шийдвэрлэх” гэж өргөдөл, гомдолд дурдсан асуудлыг бүх талаас нь судлан үзэж, түүний дагуу хууль тогтоомжид нийцүүлэн холбогдох арга хэмжээ авсныг мэдэгдэж, энэ хуульд заасан хугацаанд багтаан хариу өгөхийг”<sup>30</sup> хэлнэ гэж заасан байдаг бол академич С.Нарангэрэл “Монгол улсын хууль зүйн нэвтэрхий толь бичиг” бүтээлдээ “Төрийн байгууллага албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаагаар иргэдийн хуулиар хамгаалагдсан эрх, эрх чөлөө, ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзэж сэргээлгэхээр гаргасан хүсэлт. Гомдол гаргагч нь гомдлынхоо хариуг авах, гомдолтойгоо холбогдуулж тайлбар, нотлох баримт гаргах, гомдлоосоо татгалзан буцаан авах, өгсөн хариуг зөвшөөрөөгүй тохиолдолд зохих дээд шатны албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй”<sup>31</sup> гэж тодорхойлсон байна.

Монгол хэлний тайлбар тольд “Үйл явдал сэтгэлд нь тохироогүйгээс гуныхран, гутан шаналахын нэр: гомдол айлтгах /гомдол гаргах/, гомдол барагдах /гомдол тайлагдах/, гомдол гаргах /гомдол мэдүүлэх, гомдсоноо илэрхийлэх/, гомдол нэхэх /гомдолтой байгаагаа илэрхийлэх, гомдлоо тайлагдах /гомдохоо болих/, гомдол эрэх /гомдсон учраа илэрхийлэн өчих/” гэж тус тус тайлбарлажээ.<sup>32</sup>

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл гомдлын 35 орчим хувийг шийдвэр гүйцэтгэх ажиллагааны чиглэлээр гаргасан өргөдөл гомдол эзэлж байна.<sup>33</sup>

Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны гомдол гэж шийдвэр гүйцэтгэгчийн гаргасан шийдвэр хууль бус, шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хууль зөрчиж, эрхийг хөндсөн гэж талуудаас гаргасан гомдлыг ойлгоно.

Талуудаас гаргасан гомдлыг ахлах шийдвэр гүйцэтгэгч хүлээн авч шалган шийдвэрлэх буюу урьдчилан шийдвэрлүүлэх ажиллагаа явуулна.

Урьдчилан шийдвэрлэх ажиллагаа гэж иргэн, хуулийн этгээдийн гомдлоор дээд шатны болон гомдол хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий байгууллага, албан тушаалтнаас гомдол хянан хэлэлцэх үе шатыг хэлэх бөгөөд тухайн эрх бүхий байгууллага, албан тушаалтан гаргасан алдаагаа засах боломж олгодог.

Гомдол хангагдсан тохиолдолд шүүхээр явж, шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлж цаг алдахгүй, асуудлыг богино хугацаанд шийдвэрлэх боломжтой юм.

<sup>29</sup> Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль. УБ., 1995. Төрийн мэдээлэл эмхэтгэл №7.

<sup>30</sup> Мөн тэнд

<sup>31</sup> Монгол улсын хууль зүйн нэвтэрхий толь. УБ., 2021. 84 дэх тал.

<sup>32</sup> Монгол хэлний тайлбар толь. УБ., 2016. 127 дахь тал.

<sup>33</sup> ШШГЕГ-ын үйл ажиллагааны тоон мэдээ.

Ахлах шийдвэр гүйцэтгэгч талуудын гаргасан гомдлыг шалган шийдвэрлэх ажиллагаа явуулахдаа хэд хэдэн нөхцөл байдлыг тодруулан шалгах шаардлагатай. Үүнд:

- гомдол гаргах эрхтэй эсэх, төлөөлөх эрхийг хянах
  - хуулиар тогтоосон гомдол гаргах хугацааг хянах
  - тодорхой төрлийн ажиллагаа явуулах хуулиар тогтоосон цаг, зөвшөөрлөөр хийгдэх ажиллагааны журам зөрчсөн эсэхийг хянах
  - тодорхой төрлийн ажиллагаа явуулахдаа хуулиар тогтоосон журам зөрчсөн эсэхийг хянах
  - хөндлөнгийн гэрч оролцуулсан байдлыг хянах
  - Эрүүгийн болон зөрчлийн талаарх гомдол мэдээлэл эсэхийг хянах
- Гомдол гаргах эрхтэй эсэх, төлөөлөх эрхтэй эсэх:

Гомдол гаргагч нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх баримт бичигт заасан шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талууд эсхүл эрх ашиг нь хөндөгдсөн гуравдагч этгээд мөн эсэх, иргэний эрх зүйн зарим, эсхүл бүрэн бус чадамжтай, иргэний эрх зүйн чадамжгүй этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хангах тэдгээрийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч мөн эсэхийг гүйцэтгэх баримт бичиг, иргэний баримт бичигтэй тулган үзэх нь зүйтэй. Талуудын эрх залгамжлагч, төлөөллийн томилсон, эрх олгосон, гэрчилсэн баримт бичиг, тэдгээрийн иргэний баримт бичиг хавсаргасан эсэхийг хянах үзэх зайлшгүй шаардлагатай.

Ингсэнээр шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хамааралгүй этгээд гомдол гаргаж, ажиллагааг удаашруулах боломжийг хаах юм.

Гомдол хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа:

Хуулиар тогтоосон гомдол гаргах хугацааг хянахдаа ажиллагаа явагдсан өдрөөс эсхүл мэдсэн өдрөөс хойш 7 хоногийн дотор гомдлоо гаргасан эсэхийг гүйцэтгэх баримт бичигт авагдсан тухайн ажиллагаанаас хойш ямар хугацаа өнгөрсөн талаар хянаж, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад хугацаандаа гомдлоо гаргасан үгүйг тухайн байгууллагын өргөдөл, гомдол хүлээн авсан бүртгэлтэй тулган үзнэ.

Хугацааг цаг ажлын өдөр, хоног, сар, жилээр тооцох бөгөөд тоолж эхэлсэн минут, цаг, хоногийг хугацаа тоолоход оруулан тоолохгүйг анхаарах шаардлагатай. Мөн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны баримт бичгийг тогтоосон хугацааны сүүлийн өдрийн 24 цагийн дотор ажиллагааны талуудад хүргүүлсэн, эсвэл шуудангийн байгууллагад шилжүүлсэн бол хүргүүлсэнд тооцдог.

Зөвшөөрлөөр хийгдэх ажиллагааны журам зөрчсөн эсэх:

Шийдвэр гүйцэтгэгч иргэний шийдвэр гүйцэтгэлийг баталгаажуулах арга хэмжээг ажлын бус өдөр явуулах, эсхүл ажлын өдрийн 22.00 цагаас 06.00 цагийн хооронд гүйцэтгэх шаардлагатай тохиолдолд ахлах шийдвэр гүйцэтгэгчээс

зөвшөөрөл авч гүйцэтгэх бөгөөд явуулсан шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаар шийдвэр гүйцэтгэгчийн тэмдэглэлд тусгасан эсэхийг хянан үзнэ.

Хойшлуулшгүй нөхцөл байдлын улмаас баталгаажуулах арга хэмжээг шууд гүйцэтгэсэн тохиолдолд 24 цагийн дотор ахлах шийдвэр гүйцэтгэгчид мэдэгдэнэ. Энэ талаар тэмдэглэлд тусгаж баталгаажуулсан байхыг шаарддаг.

Хөдлөнгийн гэрч оролцуулсан эсэх:

Төлбөр төлөгчийн орон байр, эд хөрөнгө байгаа газарт нэвтрэх, эд хөрөнгөд үзлэг, нэгжлэг хийх, түүнийг хураан авах ажиллагааг хөндлөнгийн хоёроос доошгүй гэрчийн оролцоотой явуулна. Хөндлөнгийн гэрчээр иргэний эрх зүйн бүрэн чадамжтай, тухайн иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаар хувийн ашиг сонирхолгүй, өөр хоорондоо, эсхүл иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бусад оролцогчтой төрөл, садангийн, эсхүл ажил үүргийн холбоогүй хүнийг оролцуулна.

Хөндлөнгийн гэрчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, иргэний бүртгэлийн дугаар болон бусад мэдээллийг тэмдэглэлд заавал тусгасан байхыг шаардана. Мөн хөндлөнгийн гэрчид шийдвэр гүйцэтгэх ажиллагааг эхлэхийн өмнө шийдвэр гүйцэтгэгч түүний эрх, үүрэг, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаар санал гаргаж болох талаар тайлбарлаж өгнө. Хэрэв шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад хөндлөнгийн гэрчээс санал гаргасан бол энэ талаар тэмдэглэлд тусган гарын үсэг зуруулан баталгаажуулсан байна.

Битүүмжлэх, барьцаалах, хураахдаа тогтоосон журам зөрчсөн эсэхийг шалгах:

Шийдвэр гүйцэтгэгчийн битүүмжлэх, барьцаалах, хураах тухай шийдвэр хуулийн шаардлага хангасан эсэх, тэмдэглэлээр баталгаажуулсан эсэх, битүүмжилсэн хөрөнгийн захиран зарцуулах эрхийг түдгэлзүүлж бүртгэлийн байгууллагад хүргүүлсэн эсэх, эзэмших ашиглах эрх хязгаарлах ажиллагаа явуулсан эсэх, хөрөнгийн хадгалалт, хамгаалалтыг шийдвэрлэсэн эсэх, төлбөр төлөгчид төлбөр төлөх хугацаа тогтоосон эсэх, төлбөрт гаргуулахыг хориглосон хөрөнгийг битүүмжилж, хураасан эсэхийг заавал хянах шаардлагатай.

Мөн битүүмжлэх, барьцаалах, хураах ажиллагааг явуулахдаа ажлын байрандаа эсхүл тухайн байршил хаягаас өөр газар байршилд тогтоол үйлдэх, өөр өөр хаягт байрлалтай эд хөрөнгийг нэг тогтоолоор битүүмжлэх, хураах ажиллагаа явуулах, төлбөр төлөгчийн санхүүгийн блансанд тусгагдсан хөрөнгийн бүртгэлээр битүүмжлэх тогтоол үйлдэх, тухайн ажиллагааны талаар тэмдэглэл үйлдэхгүй байх зэрэг зөрчлүүд ихээхэн гардгийг анхаарах хэрэгтэй.

Төлбөр төлөгчийн мөнгөн хөрөнгө, үнэт цааснаас бусад хөрөнгийг битүүмжилсэн бол энэ тухай тэмдэглэл үйлдэж, жагсаалт гаргах ёстой.

Шинжээч томилоход анхаарах асуудал:

Шийдвэр гүйцэтгэгч хөрөнгө үнэлүүлэхээр хөрөнгийн үнэлгээчин, шинжээч томилохдоо тогтоол үйлдсэн эсэх, шинжээчид эрх, үүрэг танилцуулж, хүлээлгэх хариуцлага сануулан тэмдэглэлээр баталгаажуулсан эсэх, тогтоолд үнэлэх хөрөнгийн мэдээлэл, үнэлгээ тогтоох хугацаа зэргийг тусгасан эсэхийг хянана.

Мөн өөр өөр хаягт байршилтай хөрөнгүүдэд үнэлгээ тогтоолгох бол хөрөнгө тус бүрд шинжээч томилох тогтоол үйлдсэн байхыг шаардана. Үнэлгээг тогтоосон хугацаанд талуудад танилцуулсан эсэх, үнэлгээний талаар талуудаас гаргасан санал тэмдэглэлд тусгасан эсэхийг хянах шаардлагатай.

Гомдол хянан шийдвэрлэх:

Ахлах шийдвэр гүйцэтгэгч талуудын гаргасан гомдлыг хянаад, гаргасан гомдол нь үндэслэлтэй бол тогтоол үйлдэн гомдол гаргагчид хариуг өгч, явагдсан шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хүчингүй болгон зөвтгөх явуулахыг шийдвэр гүйцэтгэгчид даалган шийдвэрлэнэ.

Хэрэв гаргасан гомдол нь үндэслэлгүй бол гомдлыг хангахаас татгалзсан үндэслэлийг дурдан тогтоол үйлдэн хариуг өгч шийдвэрлэнэ.

Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны оролцогч талуудын гаргасан дараах гомдолд хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахгүй бөгөөд энэ нь Шүүхэд хандан гаргах буюу Шүүхийн харьяалалын гомдол юм. Үүнд:

- талуудын хөрөнгийн үнэлгээний талаарх гомдол
- битүүмжилсэн хөрөнгийг чөлөөлүүлэх бие даан шаардлага гаргасан гуравдагч этгээдийн гомдол
- хураагдсан хөрөнгийг өмчлөх эрхтэй холбоотой маргаан гомдол
- зөрчлийн үйлдлийн талаарх гомдлыг хянан шийдвэрлэх ажиллагаа тусгай журмаар зохицуулагдах

Ахлах шийдвэр гүйцэтгэгч шийдвэр гүйцэтгэх ажиллагааны оролцогчдоос гаргасан гомдол нь эрүүгийн болон зөрчлийн талаарх гомдол мэдээлэл байвал холбогдох байгууллагад шилжүүлнэ. Мөн шүүхийн харьяаллын гомдол байвал энэ талаар гомдол гаргагчид мэдэгдэн гомдлыг буцаан шийдвэрлэнэ.

---o0o---